

АЖ АХУЙ НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсрууллаа.

Монгол Улсын төсвийн тогтолцоо өндөр төвлөрсөн хэвээр байгаа бөгөөд орон нутгийн төсвийн орлогын дийлэнх хэсгийг улсын төсвөөс олгож буй санхүүгийн дэмжлэг, шилжүүлэг бүрдүүлж байна. Сангийн яамны 2025 оны төсвийн мэдээллээс үзэхэд зарим аймгийн төсвийн орлогын 60-80 гаруй хувийг улсын төсвийн шилжүүлэг эзэлж байгаа нь орон нутгийн санхүүгийн бие даасан байдал сул, хөгжлийн бодлогоо өөрөө санхүүжүүлэх чадавх хязгаарлагдмал байгааг илтгэж байна. Ийм бүтэц нь орон нутгийн хөгжлийн төсөл, дэд бүтэц, үйлдвэрлэл, логистик, эрчим хүч зэрэг урт хугацааны хөрөнгө оруулалтыг төвлөрсөн төсвөөс хэт хамааралтай байлгаж байна.

Нөгөө талаас Монгол Улсын хөрөнгийн зах зээл, тэр дундаа бондын зах зээл харьцангуй сул хөгжсөн хэвээр байна. Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооны мэдээллээр дотоодын бондын зах зээлийн хэмжээ Дотоодын нийт бүтээгдэхүүний 15-20 хувьд хүрэхгүй байгаа нь хөгжиж буй Азийн орнуудын дундажтай харьцуулахад доогуур үзүүлэлт юм. Харин Малайз Улсад энэ үзүүлэлт 90 гаруй хувь, БНСУ-д 140 орчим хувь, Тайланд Улсад 80 гаруй хувьтай байгаа нь дотоодын урт хугацааны санхүүжилтийн зах зээл хөгжсөн орнуудын нийтлэг шинж юм.

Одоогийн байдлаар Засгийн газар, Нийслэл болон Монгол Улсын Хөгжлийн банк үнэт цаас гаргах эрх зүйн орчин бүрдсэн боловч аймаг, орон нутгийн түвшинд дотоодын зах зээлээс үнэт цаас гаргах, урт хугацааны санхүүжилт татах боломж бодитоор бүрэлдээгүй байна. Үүний нэг шалтгаан нь татварын бодлогын урамшуулал, хөрөнгө оруулагчдыг татах эрх зүйн тодорхой зохицуулалт дутмаг байгаатай холбоотой юм. Тухайлбал, одоогийн хууль тогтоомжоор Засгийн газар, Нийслэл, Монгол Улсын Хөгжлийн банкны бондын хүүгийн орлогод татварын тодорхой хөнгөлөлт үйлчлэх боломжтой боловч төсвийн жилд орон нутгийн төсвөөс улсын төсөвт орлого төвлөрүүлдэг аймгийн гаргасан үнэт цаасны хүүгийн орлогод ийм зохицуулалт үйлчлэхгүй байна. Энэ нь орон нутгийн үнэт цаасыг хөрөнгө оруулагчдын хувьд сонирхол багатай болгож, шинээр бүрэлдэх бондын зах зээлийн эрэлтийг хязгаарлаж байна.

Олон улсын туршлагаас харахад орон нутгийн бондын зах зээлийг татварын бодлогоор дэмжих нь бүс нутгийн хөгжлийг санхүүжүүлэх үр дүнтэй механизм болдог. АНУ-д муж, хотын гаргасан “municipal bond”-ын хүү холбооны орлогын албан татвараас чөлөөлөгддөг бөгөөд 2024 оны байдлаар энэ зах зээлийн хэмжээ 4 их наяд ам.доллараас давж, орон нутгийн дэд бүтцийн санхүүжилтийн үндсэн эх үүсвэрийн нэг болсон байна. БНСУ, Энэтхэг, Бразил зэрэг орнууд орон нутгийн бондын зах зээлийг татварын болон зохицуулалтын бодлогоор дэмжсэнээр орон нутгийн санхүүгийн бие даасан байдал нэмэгдэж, төвлөрсөн төсвөөс хараат байдал буурсан үр дүн гарсан байна.

Монгол Улсын хувьд улсаас санхүүгийн дэмжлэг авдаггүй, өөрийн орлогоор төсвөө бүрдүүлэх боломжтой аймаг, орон нутгийг бодлогоор дэмжих шаардлага үүсэж байна. Иймд энэхүү хуулийн төслөөр төсвийн жилд орон нутгийн төсвөөс улсын төсөвт орлого төвлөрүүлдэг аймгийн гаргасан үнэт цаасны хүүгийн орлогыг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх зохицуулалтыг бий болгохоор тусгасан.

Хуулийн төсөл батлагдсанаар орон нутгийн бондын зах зээлийн анхны эрэлт бий болж, хөрөнгө оруулагчдын сонирхол нэмэгдэх, аймаг, орон нутгийн урт хугацааны санхүүжилтийн эх үүсвэр өргөжих, хөрөнгийн зах зээлийн бүтээгдэхүүний төрөлжилт нэмэгдэх, орон нутгийн санхүүгийн бие даасан байдал сайжрах зэрэг эерэг үр нөлөө бий болно. Улмаар орон нутгийн дэд бүтэц, үйлдвэрлэл, эдийн засгийн идэвхжил нэмэгдэж, татварын суурь тэлэх замаар дунд, урт хугацаанд улсын төсвийн орлогод эерэг нөлөө үзүүлэх боломжтой.

Хэдийгээр богино хугацаанд татварын орлогын тодорхой хэмжээний бууралт үүсэх боломжтой боловч уг нөлөөлөл нь харьцангуй бага бөгөөд эдийн засгийн өсөлт, хөрөнгө оруулалтын нэмэгдлээр нөхөгдөх боломжтой гэж үзэж байна.

Иймд орон нутгийн хөгжлийг дэмжих, санхүүгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, дотоодын урт хугацааны хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх зорилгоор Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

АЖ АХУЙ НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр тус хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1 дэх заалтын “Засгийн газар, Нийслэл, Монгол Улсын Хөгжлийн банкны бондын хүү” гэсний дараа “төсвийн жилд орон нутгийн төсвөөс улсын төсөвт орлого төвлөрүүлдэг аймгийн гаргасан үнэт цаасны хүү” гэж нэмэхээр тусгасан.

Төслийн 2 дугаар зүйлээр “төсвийн жилд орон нутгийн төсвөөс улсын төсөвт орлого төвлөрүүлдэг аймаг” гэсэн ойлголтыг тухайн төсвийн жилд улсын төсөвт орлого төвлөрүүлсэн аймаг гэж тодорхойлохоор тусгасан.

Төслийн 3 дугаар зүйлээр хуулийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тусгасан.

Хуулийн төсөл батлагдсанаар орон нутгийн бондын зах зээл бүрэлдэх, хөрөнгө оруулагчдын сонирхол нэмэгдэх, аймаг, орон нутгийн урт хугацааны санхүүжилтийн эх үүсвэр өргөжих, хөрөнгийн зах зээлийн төрөлжилт нэмэгдэх, орон нутгийн санхүүгийн бие даасан байдал сайжрах эерэг үр нөлөө үзүүлэх болно.